ҮНДСЭН ҮҮРЭГ, ЧИГ ҮҮРЭГ

ГХЯ-ны гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь гадаад орнуудтай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах таатай орчныг бүрдүүлэх бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлого, урт, дунд, богино хугацааны стратеги, үндсэн чиглэл, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааг төлөвлөх, бодлогын удирдамжаар хангах, гадаад бодлогын нэгдсэн зохицуулалтын хүрээнд хэрэгжилтийг нь зохион байгуулах, зохицуулах;
- гадаадын хөрөнгө оруулалтын урт, дунд, богино хугацааны бодлого боловсруулах, гадаадын хөрөнгө оруулалтын бодлого, эрх зүйн орчныг сурталчлах, хөрөнгө оруулалтыг татах таатай орчныг бүрдүүлэх бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох, олон улсын эдийн засаг, банк, санхүүгийн чиглэлийн байгууллагатай харилцахад дэмжлэг үзүүлэх;
- худалдаа, эдийн засгийн бүс нутгийн интеграцид Монгол Улс нэгдэх, оролцох чиглэлээрх бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангах, зохион байгуулах, хяналт тавих, хил орчмын худалдааны бодлогыг төлөвлөх, бодлогын удирдамжаар хангах;
- худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаатай холбогдсон асуудлаар зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.